

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Арвайхээр сумын ИТХ-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: **ӨВА-2022/193/НА-СТА-ТШЗ**

Цахим хуудас:
www.audit.mn
Улаанбаатар хот
2022 он

Тэргүүлэх аудитор: О.Батжаргал
Утас: 70323253 Цахим хаяг: batjargalo@audit.gov.mn
Аудитын менежер: Д.Гансүх
Утас: 70323833 Цахим хаяг: gansukh.audit@gmail.com
Аудитор: Ө.Ринчинмядаг
Утас: 70323108 Цахим хаяг:
rinchinmyadagu@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	9
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	11
3. Аудитын тайлан	12
3.1 Ерөнхий зүйл	12
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	13
3.4 Материаллаг байдал	13
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	13
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	13
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	14
3.8 Аудитын гол асуудал	14
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	14
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	15
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	15
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	15
4. Аудитын илрүүлэлт	15
4.1 Залруулсан алдаа	15
4.2 Төлбөрийн акт	15
4.3 Албан шаардлага	15
4.4 Зөвлөмж	16
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	16

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

62173 Арвайхээр, Өвөрхангай аймаг,
Утас/факс: (976) 7042 5600,
E-mail: uvurkhangaiaudit.gov.mn

АРВАЙХЭЭР СУМЫН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА Ц.ТУНГАЛАГ ТАНАА

2022.02.08 № 106
тантай _____-ны № _____-г

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Арвайхээр сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Арвайхээр сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолыг зөрчсөн, зардлыг зориулалт бусаар зарцуулсан зэрэг зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 16 дугаар зүйлийн 16.5.5, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7, 20 дугаар зүйлийн 20.1.4. дүгээр заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

D:\Audiitiin gazar\baiguullagiin dotood barimt\A4

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



О.БАТЖАРГАЛ

D:\Audiitiin gazar\baiguullagiin dotood barimt\A4

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН (I)	4,272,800.00	4,526,892.00
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	19,200.00	18,200.00
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	19,200.00	18,200.00
31210	Төгрөг	19,200.00	18,200.00
31213	Арилжааны банк дахь харилцах	19,200.00	18,200.00
35	БАРАА МАТЕРИАЛ	4,253,600.00	4,508,692.00
35100	Түүхий эд материал	50,000.00	50,000.00
35110	Тусгай зориулалттай материал	50,000.00	50,000.00
35400	Хангамжийн материал	4,203,600.00	4,458,692.00
35410	Бичиг хэргийн материал	358,000.00	358,000.00
35420	Аж ахуйн материал	716,100.00	971,192.00
35470	Бусад хангамжийн материал	3,129,500.00	3,129,500.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН (II)	17,345,661.06	62,928,022.55
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	17,345,661.06	62,928,022.55
39200	Биет хөрөнгө	17,345,661.06	62,928,022.55
39203	Авто-тээврийн хэрэгсэл	-	46,480,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл - Тээврийн хэрэгсэл	-	1,161,999.99
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	14,052,200.00	15,552,200.00
39206	Хуримтлагдсан элэгдэл - Тоног төхөөрөмж	- 1,985,589.06	- 4,480,617.90
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	19,915,606.00	22,915,606.00
39208	Хуримтлагдсан элэгдэл - Тавилга	- 14,636,555.88	- 16,377,165.56
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН (III=I+II)	21,618,461.06	67,454,914.55
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР (IV)	- 0.00	- 0.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН (V)	21,618,461.06	67,454,914.55
51	Засгийн газрын хувь оролцоо	21,618,461.06	67,454,914.55
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	28,237,578.06	28,237,578.06
51200	Хуримтлагдсан үр дүн	- 7,710,084.35	- 38,126,369.14
51210	Өмнөх үеийн үр дүн	- 7,710,084.35	- 7,710,084.35
51220	Тайлант үеийн үр дүн	-	45,836,453.49
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,090,967.35	1,090,967.35
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН (VI=IV+V)	21,618,461.06	67,454,914.55

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Код	Үзүүлэлт	Өмнөх жилийн дүн	Тайлант жилийн дүн
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	242,434,900.00	236,002,000.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,683,200.00	46,480,000.00
1200	Нийтлэг татварын бус орлого	1,683,200.00	46,480,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,200.00	-
1200042	Туслах үйл ажиллагааны орлого	1,200.00	-
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	1,682,000.00	46,480,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	240,751,700.00	189,522,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	240,751,700.00	189,522,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	240,751,700.00	189,522,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)	236,801,378.26	190,165,546.51
21	УРСГАЛ ЗАРДАЛ	236,801,378.26	190,165,546.51
210	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	224,076,844.10	183,116,366.22
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	98,055,520.00	105,011,716.00
210101	Үндсэн цалин	63,216,218.00	69,213,005.00
210104	Урамшуулал	34,839,302.00	35,798,711.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	12,476,712.84	13,168,862.71
210201	Тэтгэврийн даатгал	8,787,913.42	9,441,332.27
210202	Тэтгэмжийн даатгал	958,475.24	1,051,256.16
210203	ҮОМШӨ-ний даатгал	767,258.57	841,004.86
210204	Ажилгүйдлийн даатгал	218,696.41	143,275.20
210205	Эрүүл мэндийн даатгал	1,744,369.20	1,691,994.22
2104	Хангамж, бараа материалын зардал	5,755,783.00	6,225,638.00
210401	Бичиг хэрэг	2,115,550.00	1,948,600.00
210402	Тээвэр, шатахуун	3,053,050.00	3,337,460.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	561,383.00	856,778.00
210404	Ном, хэвлэл	-	57,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	25,800.00	25,800.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	12,500,000.00	2,253,400.00
210602	Тавилга	10,000,000.00	-
210604	Урсгал засвар	2,500,000.00	2,253,400.00
2107	Томилолт, зочны зардал	159,000.00	-
210702	Дотоод албан томилолт	159,000.00	-

Арвайхээр сумын ИТХ-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,714,350.00	103,650.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	7,567,000.00	1,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	54,450.00	64,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	70,900.00	38,650.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	22,000.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	87,415,478.26	56,353,099.51
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	69,673,700.00	43,481,081.00
210902	Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх	14,350,000.00	7,474,380.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдол	3,391,778.26	5,397,638.51
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	12,724,534.16	7,049,180.29
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	10,624,534.16	2,419,180.29
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	10,624,534.16	2,419,180.29
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,100,000.00	4,630,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,100,000.00	4,630,000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II)	5,633,521.74	45,836,453.49
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН (IV)	-	-
5	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (V)	-	-
6	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI=III+IV-V)	5,633,521.74	45,836,453.49

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын хөрөнгө оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Бусад	НИЙТ ДҮН
1	Үлдэгдэл	-	-	-	-	-
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-	-
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	-	-	-
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	-	-	-	-
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	-	-	-	-
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөгдөөгүй олз, гарз	-	-	-	-	-
7	Тайлант үеийн үр дүн	-	-	-	-	-
8	Үлдэгдэл	28,237,578.06	1,090,967.35	7,710,084.35	-	21,618,461.06
9	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-	-
10	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	28,237,578.06	1,090,967.35	7,710,084.35	-	21,618,461.06

11	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	-	-	-	-
12	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	-	-	-	-
13	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөгдөөгүй олз, гарз	-	-	-	-	-
14	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-	-
15	Тайлант үеийн үр дүн	-	-	45,836,453.49	-	45,836,453.49
16	Үлдэгдэл	28,237,578.06	1,090,967.35	38,126,369.14	-	67,454,914.55

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Код	Үзүүлэлт	Өмнөх жилийн дүн	Тайлант жилийн дүн
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	240,752,900.00	189,522,000.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,200.00	-
1200	Нийтлэг татварын бус орлого	1,200.00	-
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,200.00	-
1200042	Туслах үйл ажиллагааны орлого	1,200.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	240,751,700.00	189,522,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	240,751,700.00	189,522,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	240,751,700.00	189,522,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)	233,554,700.00	185,023,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	233,554,700.00	185,023,000.00
210	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	220,830,165.84	177,973,819.71
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	98,055,520.00	105,011,716.00
210101	Үндсэн цалин	63,216,218.00	69,213,005.00
210104	Урамшуулал	34,839,302.00	35,798,711.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	12,476,712.84	13,168,862.71
210201	Тэтгэврийн даатгал	8,787,913.42	9,441,332.27
210202	Тэтгэмжийн даатгал	958,475.24	1,051,256.16
210203	ҮОМШӨ-ний даатгал	767,258.57	841,004.86
210204	Ажилгүйдлийн даатгал	218,696.41	143,275.20
210205	Эрүүл мэндийн даатгал	1,744,369.20	1,691,994.22
2104	Хангамж, бараа материалын зардал	5,780,783.00	6,225,638.00
210401	Бичиг хэрэг	2,115,550.00	1,948,600.00
210402	Тээвэр, шатахуун	3,053,050.00	3,337,460.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	561,383.00	856,778.00
210404	Ном, хэвлэл	25,000.00	57,000.00

Арвайхээр сумын ИТХ-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	25,800.00	25,800.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	12,500,000.00	2,497,592.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	-
210602	Тавилга	10,000,000.00	-
210604	Урсгал засвар	2,500,000.00	2,497,592.00
2107	Томиллолт, зочны зардал	159,000.00	-
210702	Дотоод албан томиллолт	159,000.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,714,350.00	103,650.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	7,567,000.00	1,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	54,450.00	64,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	70,900.00	38,650.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	22,000.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	84,143,800.00	50,966,361.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	69,793,800.00	43,491,981.00
210902	Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх	14,350,000.00	7,474,380.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	12,724,534.16	7,049,180.29
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	10,624,534.16	2,419,180.29
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	10,624,534.16	2,419,180.29
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,100,000.00	4,630,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,100,000.00	4,630,000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III=I-II)	7,198,200.00	4,499,000.00
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)	-	-
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	7,199,000.00	4,500,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	7,199,000.00	4,500,000.00
223	БУСАД ХӨРӨНГӨ	7,199,000.00	4,500,000.00
223004	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	7,199,000.00	4,500,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI=IV-V)	-	-
9	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	-	-
10	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	-	-
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VII)	-	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII=III+VI+VII)	800.00	1,000.00
14	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	20,000.00	19,200.00
15	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	19,200.00	18,200.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	Өмнөх он		Тайлан он	
		Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл
11000	Мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдэл	-	-	-	19,200.00
70105	Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын үйл ажиллагаа	229,577,700.00	222,383,165.84	189,522,000.00	189,523,000.00
80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	192,998,400.00	186,332,826.56	147,191,800.00	147,192,800.00
12	Татварын бус орлого	-	-	147,191,800.00	147,191,800.00
122	Тусламж, санхүүжилтийн орлого	-	-	147,191,800.00	147,191,800.00
5 12200	Төсвөөс санхүүжих	-	-	147,191,800.00	147,191,800.00
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	192,998,400.00	186,332,826.56	147,191,800.00	147,192,800.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	192,998,400.00	186,332,826.56	147,191,800.00	145,699,689.41
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	192,998,400.00	186,332,826.56	147,191,800.00	145,699,689.41
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	69,563,700.00	67,935,901.00	75,602,500.00	74,711,116.00
1 21010	Үндсэн цалин	64,196,300.00	63,216,218.00	69,706,800.00	69,213,005.00
4 21010	Урамшуулал	5,367,400.00	4,719,683.00	5,895,700.00	5,498,111.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	9,391,100.00	8,645,992.56	10,206,300.00	9,695,332.41
1 21020	Тэтгэврийн даатгал	6,632,200.00	6,021,121.78	7,182,200.00	6,714,262.86
2 21020	Тэтгэмжийн даатгал	689,700.00	656,923.30	756,000.00	748,250.16
3 21020	ҮОМШӨ-ний даатгал	551,800.00	525,540.85	604,800.00	598,600.06
4 21020	Ажилгүйдлийн даатгал	137,900.00	128,559.57	151,200.00	137,719.01
5 21020	Эрүүл мэндийн даатгал	1,379,500.00	1,313,847.06	1,512,100.00	1,496,500.32
2104	Хангамж, бараа материалын зардал	6,009,600.00	5,780,783.00	6,241,000.00	6,225,638.00
1 21040	Бичиг хэрэг	2,175,400.00	2,115,550.00	1,944,400.00	1,948,600.00
2 21040	Тээвэр, шатахуун	3,054,000.00	3,053,050.00	3,338,300.00	3,337,460.00
3 21040	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	614,400.00	561,383.00	812,500.00	856,778.00
4 21040	Ном, хэвлэл	140,000.00	25,000.00	80,000.00	57,000.00
5 21040	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	25,800.00	25,800.00	65,800.00	25,800.00

Арвайхээр сумын ИТХ-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	21,300,000.00	19,699,000.00	7,000,000.00	6,997,592.00
1	21060 Багаж, техник хэрэгсэл	7,800,000.00	7,199,000.00	1,500,000.00	1,500,000.00
2	21060 Тавилга	10,000,000.00	10,000,000.00	3,000,000.00	3,000,000.00
4	21060 Урсгал засвар	3,500,000.00	2,500,000.00	2,500,000.00	2,497,592.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хураамж	164,000.00	127,350.00	166,000.00	103,650.00
1	21080 Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	20,000.00	2,000.00	-	1,000.00
3	21080 Даатгалын үйлчилгээ	64,000.00	54,450.00	64,000.00	64,000.00
4	21080 Тээврийн хэрэгслийн татвар	80,000.00	70,900.00	80,000.00	38,650.00
5	21080 Тээврийн хэрэгслийн оношилгоо	-	-	22,000.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	86,570,000.00	84,143,800.00	47,976,000.00	47,966,361.00
1	21090 Бараа үйлчилгээний бусад зардал	72,220,000.00	69,793,800.00	40,500,000.00	40,491,981.00
2	21090 Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	14,350,000.00	14,350,000.00	7,476,000.00	7,474,380.00
80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	2,100,000.00	2,100,000.00	4,678,000.00	4,678,000.00
12	Татварын бус орлого	-	-	4,678,000.00	4,678,000.00
122	Тусламж, санхүүжилтийн орлого	-	-	4,678,000.00	4,678,000.00
5	12200 Төсвөөс санхүүжих	-	-	4,678,000.00	4,678,000.00
2	НИИТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,100,000.00	2,100,000.00	4,678,000.00	4,678,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,100,000.00	2,100,000.00	4,678,000.00	4,630,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,100,000.00	2,100,000.00	4,678,000.00	4,630,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,100,000.00	2,100,000.00	4,678,000.00	4,630,000.00
9	21320 Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,100,000.00	2,100,000.00	4,678,000.00	4,630,000.00
80825	Багийн ИНХ-ын дарны урамшуулал	34,479,300.00	33,950,339.28	34,652,200.00	34,652,200.00
12	Татварын бус орлого	-	-	34,652,200.00	34,652,200.00
122	Тусламж, санхүүжилтийн орлого	-	-	34,652,200.00	34,652,200.00
5	12200 Төсвөөс санхүүжих	-	-	34,652,200.00	34,652,200.00
2	НИИТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	34,479,300.00	33,950,339.28	34,652,200.00	34,652,200.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	34,479,300.00	33,950,339.28	34,652,200.00	33,774,130.30
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	34,479,300.00	33,950,339.28	34,652,200.00	33,774,130.30
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	30,378,200.00	30,119,619.00	30,530,600.00	30,300,600.00

Арвайхээр сумын ИТХ-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд
хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

4	21010	Урамшуулал	30,378,200.00	30,119,619.00	30,530,600.00	30,300,600.00
	2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	4,101,100.00	3,830,720.28	4,121,600.00	3,473,530.30
1	21020	Тэтгэврийн даатгал	2,885,900.00	2,766,791.64	2,900,400.00	2,727,069.41
2	21020	Тэтгэмжийн даатгал	303,800.00	301,551.94	305,300.00	303,006.00
3	21020	ҮОМШӨ-ний даатгал	243,000.00	241,717.72	244,200.00	242,404.80
4	21020	Ажилгүйдлийн даатгал	60,800.00	90,136.84	61,100.00	5,556.19
5	21020	Эрүүл мэндийн даатгал	607,600.00	430,522.14	610,600.00	195,493.90
	82201	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх	-	-	3,000,000.00	3,000,000.00
	12	Татварын бус орлого	-	-	3,000,000.00	3,000,000.00
	122	Тусламж, санхүүжилтийн орлого	-	-	3,000,000.00	3,000,000.00
5	12200	Төсвөөс санхүүжих	-	-	3,000,000.00	3,000,000.00
	2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	-	3,000,000.00	3,000,000.00
	21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	-	3,000,000.00	3,000,000.00
	210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	-	3,000,000.00	3,000,000.00
	2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	-	3,000,000.00	3,000,000.00
1	21090	Бараа үйлчилгээний бусад зардал	-	-	3,000,000.00	3,000,000.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Нэмэлт санхүүжилт байхгүй болно.

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Арвайхээр сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд Шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Төрийн аудитын газрын аудитор аудитор Ө.Ринчинмядаг гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Д.Гансүх, газрын дарга, тэргүүлэх аудитор О.Батжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Тус байгууллага нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Өвөрхангай аймаг дахь төрийн аудитын газарт 2022.01.18-ны өдрийн 02/05 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Тус байгууллагын зорилго: Нутгийн иргэдийн хотжих соёл, ашиг сонирхолд тулгуурласан оновчтой бодлого шийдвэрээр орон нутгийнхаа хөгжлийг дэмжин, үйл ажиллагаандаа иргэдийн оролцоог хангасан, санаачилгатай нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагыг төлөвшүүлнэ. Дээрх зорилгын хүрээнд дараах зорилтуудыг дэвшүүлэн ажилласан байна. Үүнд:

Зорилт-1 Монгол улсын хууль тогтоомж, хөгжлийн чиг хандлага, зарчмын дагуу орон нутагтаа зохицсон бодлого, шийдвэр батлах, хэрэгжилтийг хангуулах.

Зорилт-2 Хурлаас хяналтын чиг үүргээ хэрэгжүүлэх арга хэлбэр, зохион байгуулалтыг боловсронгуй болгож, түүний үр нөлөөг дээшлүүлнэ.

Зорилт-3 Хурлын үйл ажиллагааны үндсэн хэлбэр болох хуралдааны зохион байгуулалт, чанар, үр нөлөөг дээшлүүлнэ.

Зорилт-4 Төлөөлөгчийн ажиллах нөхцөл боломж чадавхыг дээшлүүлж, идэвх оролцоо, хариуцлагыг нэмэгдүүлнэ.

Зорилт-5 Арвайхээр сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурлын үйл ажиллагааг олон нийтэд сурталчилж, ил тод, нээлттэй байдлыг бүх талаар хангана.

Зорилт-6 Арвайхээр сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурлын гадаад, дотоод харилцааг хөгжүүлнэ
Зорилт-7 Арвайхээр сумын иргэдийн төлөөлөгчдийн хурлын ажлын албыг мэргэшүүлэх, үйл ажиллагааны зохион байгуулалт, чанарыг сайжруулна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллага нь Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиггүй байна.

Тус газар нь хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газаргүй болно.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Арвайхээр сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь нийт зардлын үзүүлэлтээр сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны 12 дугаар сарын 31-ны байдлаар 190.1 сая төгрөгөөс 1 хувиар буюу 1.9 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 1.5 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Тус байгууллагын хувьд тайлант онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 46.48 сая төгрөгийн тээврийн хэрэгсэл нэмэгдсэн. Мөн 2021 онд багаж техник хэрэгслийн зардлаас 1.5 сая төгрөгөөр суурин компьютер, тавилга эд хогшлын зардлаас 3 сая төгрөгөөр ширээ, сандал худалдан авсан. Бараа материалын хувьд өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гараагүй байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус газар нь өөрийн орлого байхгүй.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх үйл ажиллагаанд зориулан 189.522 сая төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ. Санхүүжилт өмнөх оноос 17.45 хувиар буурсан байна. Энэ бараа үйлчилгээний бусад зардал, эд хогшил, урсгал засварын зардал буурсантай холбоотой юм.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 189.5 сая төгрөгөөр санхүүжигдэн, 189.5 сая төгрөгийг үйл ажиллагааны зардалд зарцуулжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тус байгууллага тайлант онд нэмэлт санхүүжилт байхгүй болно.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Тайлант онд 3.0 сая төгрөгийн тавилга, эд хогшил худалдан авсан нь Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолыг хэрэгжүүлээгүйгээс үүдэлтэй гарсан зөрчил юм. Мөн хөрөнгө зарцуулах, тэтгэмжийн шийдвэрүүдийн хувьд үндэслэл зөрүүтэй, хүчингүй болсон дүрэм, журмыг үндэслэдэг зэрэг дотоод хяналт сул байдалтай холбоотой гарсан зөрчлүүд нь аудитын хувьд гол онцлох асуудал байна.

3.8 Аудитын гол асуудал

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 4 чиглэлээр аудитын 3 горим сорил гүйцэтгэсэн.

Материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал, тайлант хугацаанд гарсан нөлөө бүхий ажил гүйлгээ, үйл явдлыг аудитын гол асуудлыг тодорхойлоход харгалзаж үзсэн.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудаст 3,810.0 мянган төгрөгийн 7 хөрөнгө зарцуулсан шийдвэрийг байршуулаагүй байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 16 дугаар зүйлийн 16.5.5, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7, 20 дугаар зүйлийн 20.1.4 дэх заалтуудад тус тус нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Шилэн дансанд санхүүжилтийг сар бүр мэдээлж ажилласан байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Хөрөнгө зарцуулах тушаалуудын үндэслэл, тэдгээрийн хүчин төгөлдөр байдал.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 9.3 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 5.5 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, 3.8 сая төгрөгийн алдаа зөрчилд 1 зөвлөмж өгсөн.

4.1 Залруулсан алдаа

Байхгүй болно.

4.2 Төлбөрийн акт

Байхгүй болно.

4.3 Албан шаардлага

Тавилга, эд хогшил 3,000.0 мянган төгрөгөөр худалдан авсан. Мөн яруу найргийн үдэшлэгт дэмжлэг 500.0 мянган төгрөгийн дэмжлэгийг бараа үйлчилгээний бусад зардлаас зориулалт бусаар олгосон байна.

Албан хаагчдад тэтгэмжийг хавтгайруулан олгосон. ИТХ-ын дарга Ц.Доньддорж, жолооч Ч.Тогооч нарт хүчингүй болсон дотоод журмыг үндэслэн 1,000.0 төгрөгийн тэтгэмж; ИТХ-ын нарийн бичгийн дарга Ц.Тунгалагт дотоод журам, бусад холбогдох эрх зүйн актад бүрэн нийцээгүй үндэслэлээр, анхан шатны баримтгүйгээр 400.0 мянган төгрөгийн дэмжлэг тус тус олгосон. Мөн байгууллагын дотоод журмын 6.4-д албан хаагчийн гэр бүлийн гишүүн нас барахад 100.0 төгрөгийн нэг удаагийн буцалтгүй тусламж олгоно гэж заасан байхад 600.0 мянган төгрөгийн тэтгэмж олгосон байна.

Бараа үйлчилгээний бусад зардлаас нэг удаагийн тэтгэмж 100.0 /тамгын газрын жижүүрт урамшуулал олгосон/.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Шилэн дансны цахим хуудаст 3,810.0 мянган төгрөгийн 7 хөрөнгө зарцуулсан шийдвэрийг байршуулаагүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг бүрэн хангаж, хуульд заасан хугацаанд мэдээллийг байршуулах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 05 дугаар сарын 01 -ний өдрийн дотор ирүүлнэ үү.


Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Арвайхээр сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурал	4	9.31	0	0	0	0	3	5.5	1	3.8

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  О. БАТЖАРГАЛ

АУДИТЫН МЕНЕЖЕР  Д. ГАНСҮХ

БЭЛТГЭСЭН

АУДИТОР  Ө.РИНЧИНМЯДАГ

2022 ОНЫ 02 ДУГААР САРЫН 08-НЫ ӨДӨР



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 сарын 03 өдөр

Дугаар 02/105/НА СТА-ТНУС/МС90355/69 Арвайхээр

Арвайхээр сумын Иргэдийн
Төлөөлөгчдийн хурлын нарийн
бичгийн дарга Ц.Тунгалаг танаа
Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд тус байгууллагын 2021 оны санхүүгийн тайлангийн аудит хийхэд дараах зөрчил илэрлээ. Үүнд:


Албан хаагчдад тэтгэмжийг хавтгайруулан олгосон. ИТХ-ын дарга Ц.Доньддорж, жолооч Ч.Тогооч нарт хүчингүй болсон дотоод журмыг үндэслэн 1,000.0 төгрөгийн тэтгэмж; ИТХ-ын нарийн бичгийн дарга Ц.Тунгалагт дотоод журам, бусад холбогдох эрх зүйн актад бүрэн нийцээгүй үндэслэлээр, анхан шатны баримтгүйгээр 400.0 мянган төгрөгийн дэмжлэг тус тус олгосон. Мөн байгууллагын дотоод журмын 6.4-д албан хаагчийн гэр бүлийн гишүүн нас барахад 100.0 төгрөгийн нэг удаагийн буцалтгүй тусламж олгоно гэж заасан байхад 600.0 мянган төгрөгийн тэтгэмж олгосон байна.

Энэхүү зөрчил нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7."Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.", 20 дугаар зүйлийн 20.1.4.-д "хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх;" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4 дүгээр зүйлийн 4.2.1.11-д заасан "хууль, тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Дээрх зөрчлүүдийг арилгаж, биелэлтийг 2022 оны 05 дугаар сарын 01-ний дотор Өвөрхангай аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх;

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Арвайхээр сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын нарийн бичгийн дарга Ц.Тунгалаг, нягтлан бодогч Н.Наранчимэг нарт даалгав.²

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:
ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  О.БАТЖАРГАЛ
АУДИТОР  Ө.РИНЧИНМЯДАГ

² Акт албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 42.1 Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно.



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 сарын 08 өдөр

Дугаар ӨА-2022/009/И-СГА-ТШС/А1590359/68 Арвайхээр

Арвайхээр сумын Иргэдийн
Төлөөлөгчдийн хурлын нарийн
бичгийн дарга Ц.Тунгалаг танаа
Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд тус байгууллагын 2021 оны санхүүгийн тайлангийн аудит хийхэд дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

1. Тавилга, эд хогшил 3,000.0 мянган төгрөгөөр худалдан авсан. Мөн яруу найргийн үдэшлэгт дэмжлэг 500.0 мянган төгрөгийн дэмжлэгийг бараа үйлчилгээний бусад зардлаас зориулалт бусаар олгосон байна.

2. Бараа үйлчилгээний бусад зардлаас нэг удаагийн тэтгэмж 100.0 мянган төгрөг /тамгын газрын жижүүрт урамшуулал олгосон/ олгож зардлыг зориулалт бусаар зарцуулсан.

Эдгээр зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах"; Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.4-д "... албан конторын тавилга, албаны болон ажлын дүрэмт хувцас, амралт, алжаал тайлах, фитнесийн тоног төхөөрөмж, хэрэглэлийн худалдан авалтыг зохион байгуулахгүй байх", 1.6-д "Засгийн газрын шийдвэр гарснаас бусад баяр ёслол, тэмдэглэлт ой, урлагийн наадам, спортын уралдаан тэмцээн, салбарын өдөр, аялал зугаалга зэргийг зохион байгуулахгүй байх;" гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4 дүгээр зүйлийн 4.2.1.11-д заасан "хууль, тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Дээрх зөрчлүүдийг арилгаж, биелэлтийг 2022 оны 05 дугаар сарын 01-ний дотор Өвөрхангай аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх;

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Арвайхээр сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын нарийн бичгийн дарга Ц.Тунгалаг, нягтлан бодогч Н.Наранчимэг нарт даалгав.¹

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:
ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  О.БАТЖАРГАЛ
АУДИТОР  Ө.РИНЧИНМЯДАГ

¹ Акт албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 42.1 Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно.